

2023.02.28

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГЫГ СУДЛАН БҮРТГЭХ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт хөдөлмөрийн харилцаанд оролцогч нь хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн болон түүнтэй адилтгах хүчин зүйлийн үйлчлэлд өртөх, эсхүл цацраг болон биологийн идэвхт бодис, химийн хорт бодисын нөлөөгөөр хурц, цочмог хэлбэрээр хордохтой холбоотой үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг мэдээлэх, шалтгаан, хүчин зүйлийг судалж бүртгэх, хянан баталгаажуулах, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү дүрмийн зорилго оршино.

1.2. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх үйл ажиллагаанд Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Шүүх шинжилгээний тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү дүрмийг мөрдөнө.

1.3. Энэ дүрмийг Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн байгууллага (цаашид "ажил олгогч" гэх), иргэд, хуульд өөрөөр заагаагүй бол гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаадын болон гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд нэгэн адил мөрдөнө.

1.4. Гадаадад ажиллах хүч, мэргэжилтэн гаргах эрх бүхий байгууллага, аж ахуйн нэгжээр зуучлуулан гадаадад ажиллаж байгаа иргэн үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн тохиолдолд хуульд өөрөөр заагаагүй бол тухайн улсын хууль тогтоомжийн дагуу үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэнэ.

1.5. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн ажилтан, иргэн (цаашид "осолдогч" гэх)-д анхан шатны тусламж үзүүлэх, эмнэлэгт хүргэх, эрүүл мэндийн яаралтай үзлэг шинжилгээ хийлгэх, осол, хордлогын улмаас бий болсон аюултай нөхцөл байдлыг шуурхай арилгах, осол, хурц хордлогыг судлан бүртгэхэд шаардагдах зардлыг ажил олгогч бүрэн хариуцна. Мөн үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улмаас нас барсан ажилтны гэр бүлд болон хөдөлмөрийн чадвар алдсан ажилтанд олгох нөхөн төлбөрийг Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу олгоно.

1.6. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус комиссын ажиллах аргачилсан зааврыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж мөрдүүлнэ.

Хоёр. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын талаарх мэдээлэл дамжуулах болон зохион байгуулалтын зарим арга хэмжээ

2.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 4.1-д заасан хөдөлмөр эрхлэгч иргэн дараах тохиолдолд гэмтсэн, хордсон, эсхүл амь насаа алдсан бол холбогдох байгууллагуудад 48 цагийн дотор цахимаар, эсвэл утсаар мэдээлнэ:

2.1.1 ажлын байрандаа ажил үүргээ гүйцэтгэж байх үед;

2.1.2 ажил олгогч болон эрх бүхий бусад байгууллагаас гаргасан шийдвэрийн дагуу албан томилолтоор, дайчилгаагаар ажиллах, сургалт болон олон нийтийн арга хэмжээнд оролцох үед ;

2.1.3 ажлын байр, нэгж, хэсэг, салбарын хооронд байнга явж ажил, үүрэг гүйцэтгэдэг ажилтан ажлын цагаар бүх төрлийн тээврийн хэрэгсэл, ердийн хөсгөөр буюу явган явж байх үед;

2.1.4 ажилтан ажил эхлэхийн өмнө болон дууссаны дараа ажлын байрандаа амрах, багаж хэрэгслээ эмхэлж цэгцлэх, хувцсаа солих, усанд орох, ажил хүлээлцэх үед;

2.1.5 ажилтан ажилдаа ирэх, буцах зам (ажлын байр болон ажилтай холбоотой сургалтад оролцож байгаа, түр болон байнга оршин суудаг газар, голлон хооллодог, цалингаа авдаг газрын хооронд)-даа бүх төрлийн тээврийн хэрэгсэл, ердийн хөсгөөр буюу явган явж байх үед;

2.1.6 ажил, үүргээ гүйцэтгэх үед байгаль, цаг уур, гал, усны гэнэтийн аюул, цацраг идэвхит болон химийн бодисын нөлөөлөл, биологийн гаралтай гоц халдварт өвчин үүсгэгч, хөнөөх хэрэгсэл, сүйрэл, дэлбэрэлт зэрэг гамшгийн үед.

2.2. Осол, хурц хордлогод өртсөн талаар осолдогч өөрөө, эсхүл осол, хордлого гарсан талаар уг нөхцөл байдлыг анх харсан этгээд ажил олгогчид болон холбогдох байгууллагад нэн даруй утсаар болон цахим сүлжээ ашиглан мэдээлнэ.

2.3. Мэдээллийг хүлээн авсан ажил олгогч болон холбогдох эрх бүхий албан тушаалтан нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх комисс (цаашид комисс гэх)-ыг яаралтай осол, хурц хордлого болсон ажлын байр, талбайд ажиллуулж, осолдогчид анхан шатны тусламж үзүүлж, эмнэлэгт хүргүүлэн, яаралтай үзлэг шинжилгээнд хамруулж, шуурхай арга хэмжээ зохион байгуулна.

2.4. Ажил олгогч нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн иргэн, ажилтныг өөрийн зардлаар эмнэлэгт хүргэх, шаардлагатай үзлэг шинжилгээний болон осол, хурц хордлогын хор уршгийг арилгах арга хэмжээний зардлыг хариуцна.

2.5. Комисс нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын талаар дараах байгууллагад энэхүү дүрмийн 2 дугаар хавсралтаар баталсан “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тухай яаралтай мэдэгдэх хуудас”-ын дагуу үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын цахим бүртгэлийн /<http://om.inspection.gov.mn/> системд цахимаар, бичгээр болон утсаар мэдэгдэнэ:

2.5.1. осолдогчийн эрүүл мэндэд учирсан хохирлын хэмжээнээс үл хамааран орон нутгийн хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад;

2.5.2. үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улмаас хүний амь нас хохирсон тохиолдолд орон нутгийн хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад болон цагдаагийн байгууллагад мэдэгдэх;

2.6. Ажил олгогч (комисс) нь цагдаа, хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын байцаагч, комисс судалгаа, шинжилгээ хийх хүртэлх хугацаанд үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан ажлын байрыг хамгаалалтад авна.

2.7. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан ажлын байрыг хамгаалалтад авах нь ажлын байрны хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, эсхүл бусад ажилтны эрүүл мэнд, орчны аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхөөр бол ажил олгогч нөхцөл байдлыг дүрс бичлэг, гэрэл зураг болон бүдүүвч зургаар баримтжуулсан байна.

2.8. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын комисс нь яаралтай холбогдох гэрчүүдийг тогтоох, бичиг баримтууд болон ослын нөхцөл байдлыг баримтжуулах арга хэмжээг авна.

Гурав. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус комиссын төрөл, үйл ажиллагааны хамрах хүрээ

3.1. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын шалтгаан, хүчин зүйлийг судлан бүртгэсэн акт, дүгнэлт гаргах эрх, үүрэг бүхий үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус комисс нь дараах 3 төрөлтэй байна. Үүнд:

3.1.1 Ажил олгогчийн тушаалаар байгуулсан орон тооны бус байнгын комисс,

3.1.2 Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулсан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус комисс,

3.1.3 Засгийн газраас томилсон ноцтой хор аюул, хохирол ихтэй үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх комисс.

3.2. Энэхүү дүрмийн 3.1.-д заасан комисс нь ажил олгогчийн болон ажилтны төлөөлөл бүхий 3-аас дээш гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Комиссын даргыг болон гишүүдийг эрхэлж буй албан тушаалаар нь ажил олгогч томилно.

Тухайн байгууллагын ажилтны тооноос хамааран гишүүдийн тоог нэмж болно. Бүрэлдэхүүн заавал сондгой гишүүнчлэлтэй байх шаардлагатай.

3.3. Ажил олгогчийн тушаалаар байгуулсан комисс нь дараах үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэж ажиллана.

3.3.1. тухайн байгууллагын ажилтан, албан хаагчид үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн,

3.3.2. төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэгч албанд ажилладаг албан хаагч үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн,

3.3.3. томилолтоор буюу гэрээгээр, эсхүл дайчилгаагаар тухайн байгууллагад ажил, үүрэг гүйцэтгэж байгаа ажилтан, ~~шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба болон цагдаагийн байгууллагын ажилтан~~, цэргийн жинхэнэ алба хаагч, цэргийн сургуулийн сонсогч, хоригдол, дадлага хийж байгаа суралцагч үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн,

Тайлбар: Энэхүү дүрмийн 3.1.1-д заасан комиссын бүрэлдэхүүнд осолдогчийн харьяалах байгууллагын төлөөллийг оролцуулна.

3.3.4. Иргэн, хуулийн этгээд нь гэрээгээр ажил гүйцэтгэх, гүйцэтгүүлэх, машин механизм, тоног төхөөрөмж түрээслэх буюу бусад хэлбэрээр ашиглах үед тухайн байгууллагад ажилладаггүй, гуравдагч этгээд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод

өртсөн /холбогдох гэрээнд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг хэрхэн судлан бүртгэх талаар тодорхой тусгаагүй тохиолдолд/

3.4. Энэхүү дүрмийн 3.1.2-д заасан комисс нь Засаг даргын Тамгын газраас нэг, ажил олгогч болон ажилтны төлөөллөөс тус бүр хоёр хүний бүрэлдэхүүнтэй байна. Комиссын даргыг болон гишүүдийг Засаг даргын захирамжаар тухайн осол, хурц хордлого гарсан тохиолдол тус бүрд томилно.

3.5. Засаг даргын захирамжаар байгуулсан комисс нь хөдөлмөрийн гэрээнээс өөр төрлийн гэрээгээр ажил, үүрэг гүйцэтгэгч, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч болон хувиараа хөдөлмөр эрхлэгч, хоршоо, нөхөрлөлийн гишүүн, малчин, гэрийн үйлчлэгч хөдөлмөр эрхлэх явцад үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэж ажиллана.

3.6. Энэхүү дүрмийн 3.1.3-д заасан комисс нь Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон тухайн осол, хурц хордлого гарсан салбарт хамаарах салбарын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, онцгой байдлын асуудал хариуцсан байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллөөс тус бүр хоёр хүний бүрэлдэхүүнтэй байна. Комиссын дарга болон гишүүдийг Засгийн газрын шийдвэрээр тухайн осол, хурц хордлого гарсан тохиолдол тус бүрд томилно.

3.7. Засгийн газраас томилсон комисс нь ноцтой хор аюул, хохирол ихтэй, олон нийтийг хамарсан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэж ажиллана.

3.8. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус комисс нь осолдогчийг нийгмийн даатгалд хамрагдсан эсэхийг үл харгалзан энэхүү дүрмийн дагуу судлан бүртгэнэ.

Дөрөв. Комиссын эрх, үүрэг

4.1. Комисс нь дараах эрхтэй байна:

4.1.1. үйлдвэрлэл, үйлчилгээний талбай болон ажлын байранд нэвтрэн орж, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын нөхцөл байдалтай биечлэн танилцах;

4.1.2. мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө, тусламж авах зорилгоор шаардлагатай тохиолдолд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх ажиллагаанд мэргэжилтэн, шинжээч оролцуулах, ослын талаар техникийн тооцоо, лабораторийн шинжилгээ, туршилт хийлгүүлэх, осол гарсан ажлын байрны эрсдэлийн үнэлгээг дахин хийлгэж, дүгнэлт гаргуулах;

4.1.3. осолдогч болон осол, хурц хордлого гарах үед байсан гэрч, бусад этгээдээс тайлбар, мэдээлэл, ярилцлага авах, холбогдох бичиг баримттай танилцах;

4.1.4. үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх явцад шаардлагатай ажлын байр, техник хэрэгсэл, унаагаар хангуулах.

4.2. Комисс нь дараах үүргийг гүйцэтгэнэ:

4.2.1. нөхцөл байдалтай газар дээр нь танилцан, судалж бүртгэх үйл ажиллагааг эхлүүлэх;

4.2.2. үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарахад хүргэж болзошгүй бөгөөд бусдын амь нас, эрүүл мэндэд аюултай, ажлын байрны хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан, орчны аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлийг арилгах арга хэмжээг шуурхай зохион байгуулах талаар ажил олгогчид шаардлага тавих, зөвлөмж өгөх;

4.2.3. үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх явцад гарсан иргэдийн гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч, ажлын 3 хоногийн дотор магадлан шалгаж шийдвэрлэх;

4.2.4. осол, хурц хордлогын нөхцөл байдлыг баримтжуулан, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэхэд шаардлагатай баримт бичгүүдийг бүрдүүлэх;

4.2.5. үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын шалтгаан, хүчин зүйлийг судлан бүртгэсэн акт, дүгнэлтийг үндэслэн нийт ажилтнуудад осол, хурц хордлого гарсан шалтгаан, нөхцөл болон цаашид үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар мэдээлэл өгч, сэрэмжлүүлэх арга хэмжээг нэн даруй авах, ажил олгогчид шаардлага, зөвлөмж хүргүүлэх;

4.2.6. Комисс нь шаардлагатай тохиолдолд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын шалтгаан, хүчин зүйлийн талаар хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчаас, мөн тухайн чиглэлээр төрөлжсөн ажил олгогчоос хараат бус мэргэжилтэн, шинжээч, мэргэжлийн байгууллагаар зөвлөгөө мэдээлэл авч болно.

4.3. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого судлан бүртгэх орон тооны бус комиссын гишүүдэд урамшуулал олгох, шаардлагатай мэргэшил арга зүй, хамгаалах хэрэгслээр хангах үйл ажиллагааг ажил олгогч болон бүх шатны засаг дарга хэрэгжүүлнэ.

Ажил олгогч нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлого судлан бүртгэх орон тооны бус комиссын гишүүдэд урамшуулал олгоно.

Комиссын дарга, гишүүдэд ослын бүртгэл, хурал зохион байгуулах гэх мэт ажилласан цагаар нь тооцож тухайн бүр урамшуулал олгох бөгөөд нэг цагийн урамшууллын хэмжээ нь Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооноос баталсан хөдөлмөрийн хөлсний нэг цагийн доод хэмжээг 3 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна.

Энэхүү дүрмийн 1-т заасан зардлыг аж ахуй нэгж, байгууллага бүр тухайн жилийн төсөвт суулган хэрэгжүүлнэ.

Тав. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын чиг үүрэг

5.1. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэхтэй холбогдсон үйл ажиллагаанд аймаг, дүүргийн Засаг дарга дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ.

5.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 4.1-д заасан хөдөлмөр эрхлэгч иргэн үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртөхөөс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон үйл ажиллагааг тогтмол зохион байгуулан ажиллаж, энэ чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран ажиллах

5.3. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссын үйл ажиллагаанд анхаарч, гишүүдийг чадавхижуулах сургалтанд хамруулах, мэдлэг чадварыг нь дээшлүүлэх

5.4. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоос урьдчилан сэргийлэх чиглэлээр орон нутгийн төсөвт тодорхой санхүүжилтийг тусган хэрэгжүүлэх

5.5. Ажил олгогч, ажилтаны хандлага, соён гэгээрүүлэх ажил зохион байгуулах

5.6. Энэ дүрмийн 3.5-т заасан ослын үнэн зөв бүртгэж цаг хугацаанд нь бүртгэн мэдээлж байх

Зургаа. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэхэд бүрдүүлэх бичиг баримт

6.1. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэхэд дараах бичиг баримтыг бүрдүүлнэ:

6.1.1. осолдогчоос авсан тайлбар, ярилцлагын тэмдэглэл;

6.1.2. осолдогч нас барсан болон хүнд гэмтэл, хордлогын улмаас улмаас өөрөө өөртөө үйлчлэх чадваргүй, бусдын асаргаа сувилгаа шаардлагатай болсон, байнгын хэвтэрт байгаа тохиолдолд гэрчийн тодорхойлолт, түүний ярилцлагын тэмдэглэл;

6.1.3. үйлдвэрлэлийн осол, хурц хордлоготой холбоотой асуудлаар холбогдох хүмүүсээс авсан мэдээлэл, ярилцлагын тэмдэглэл;

6.1.4. үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан ажлын байр, тоног төхөөрөмж, техник, багаж хэрэгслийн гэрэл зураг болон бүдүүвч зураг, схем, дүрс бичлэг;

6.1.5. осолдогчийн ажилд орсон тухай шийдвэр, хөдөлмөрийн гэрээ, ажлын тушаалын тодорхойлолт, ажлын цаг бүртгэлийн талаарх мэдээлэл, аюулгүй ажиллагааны зааварчилгаа авч байсан бүртгэл, сургалтад хамрагдсан, шалгалт өгч тэнцсэнийг гэрчлэх болон бусад шаардлагатай баримтын хуулбар;

6.1.6. осолдогчид олгосон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн баримтын хуулбар;

6.1.7. технологийн заавар, аюулгүй ажиллагааны дүрэм, журам, заавар, тушаал, хууль тогтоомжийн холбогдох хэсгийн хуулбар;

6.1.8. тухайн ажлын байранд хийсэн эрсдэлийн үнэлгээний хуулбар;

6.1.9. холбогдох байгууллагуудад хүргүүлсэн үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын талаарх яаралтай мэдэгдэх хуудас;

6.1.10. Тусламж, үйлчилгээ үзүүлсэн эрүүл мэндийн байгууллагын анхан шатны бүртгэл, хяналтын хуудас, өвчтөний түүх (амбулаторийн карт), холбогдох оношилгоо, шинжилгээ, дүгнэлтийн хуулбар;

6.1.11. Эрүүл мэндийн хохирлын зэргийг буюу гэмтлийн зэрэг тогтоосон Шүүх шинжилгээний байгууллагын шинжээч эмчийн дүгнэлтийн хуулбар;

6.1.13. Холбогдох хяналтын улсын байцаагч, мэргэжилтэн, шинжээч болон мэргэжлийн байгууллагын дүгнэлт (дүгнэлт гарсан тохиолдолд);

6.1.12. Хэрэв эмнэлгийн хуудас олгогдсон байвал осол, хурц хордлогод өртсөн хүний байнга болон түр оршин суугаа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагаас болон тусламж, үйлчилгээ үзүүлсэн эрүүл мэндийн байгууллагаас олгосон эмнэлгийн хуудас;

5.1.14. Хэрэв осолдогч нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ердийн өвчин болон ахуйн ослоор хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг тогтоолгосон байвал хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь хэмжээ, хугацааг тогтоосон акт;

6.1.15. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэсэн акт (цаашид "акт" гэх) /Дүрмийн 1 дүгээр хавсралтаар баталсан актыг бөглөсөн байна/

Долоо. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан, акт тогтоох

7.1. Энэхүү дүрмийн 6.1-д хамаарах баримт бичиг, мэдээлэл тайлбар, ослын нөхцөл байдлын фото зураг, бичлэг, холбогдох мэргэжлийн байгууллагуудын үзлэг шинжилгээний дүгнэлтээр хөдөлмөр эрхлэгч иргэн нь ажил үүргээ гүйцэтгэхтэй холбоотойгоор дараах тохиолдолд өртсөний улмаас гэмтсэн, өвчилсөн, эсхүл амь насаа алдсан нь нотлогдсон тохиолдолд комисс акт тогтооно. Үүнд:

7.1.1. ажлын байрандаа ажил үүргээ гүйцэтгэж байх үед;

7.1.2. ажил олгогч болон эрх бүхий бусад байгууллагаас гаргасан шийдвэрийн дагуу албан томилолтоор, дайчилгаагаар ажиллах, сургалт болон олон нийтийн арга хэмжээнд оролцох үед;

Тайлбар: Энэ ослыг судлан бүртгэхдээ энэхүү дүрмийн 7.1.2-д дурдсан нөхцөл байдлын удирдамж, шийдвэр, оролцогчдын бүртгэл зэргийг үндэс болгоно.

7.1.3. ажлын байр, нэгж, хэсэг, салбарын хооронд байнга явж ажил, үүрэг гүйцэтгэдэг ажилтан ажлын цагаар бүх төрлийн тээврийн хэрэгсэл, ердийн хөсгөөр буюу явган явж байх үед;

Тайлбар: Энэ ослыг судлан бүртгэхдээ энэхүү дүрмийн 7.1.5-д дурдсан нөхцөл байдлын чиглэл, маршрут, цаг хугацаа зэргийг үндэс болгоно. Бүх төрлийн тээврийн хэрэгсэлтэй холбоотой осолд Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын дүгнэлтийг үндэслэнэ.

7.1.4. ажилтан ажил эхлэхийн өмнө болон дууссаны дараа ажлын байрандаа амрах, багаж хэрэгслээ эмхэлж цэгцлэх, хувцсаа солих, усанд орох, ажил хүлээлцэх үед болон уртын ээлжээр ажиллагсад ээлжийн хугацаанд амралтын байр дээрээ амарч байх үедээ;

7.1.5. ажилтан ажилдаа ирэх, буцах зам (ажлын байр болон ажилтай холбоотой сургалтад оролцож байгаа, түр болон байнга оршин суудаг газар, голлон

хооллодог, цалингаа авдаг газрын хооронд)-даа бүх төрлийн тээврийн хэрэгсэл, ердийн хөсгөөр буюу явган явж байх үед;

Тайлбар: Энэ ослыг судлан бүртгэхдээ энэхүү дүрмийн 7.1.5-д дурдсан нөхцөл байдлын чиглэл, маршрут, цаг хугацаа зэргийг үндэс болгоно. Бүх төрлийн тээврийн хэрэгсэлтэй холбоотой осолд Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын дүгнэлтийг үндэслэнэ.

7.1.6. Ажлын байрандаа ажил үүргээ гүйцэтгэж байх үедээ гадны халдлагад өртөх;

Тайлбар: Цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэлтийн материалаас зөвшөөрлийн хүрээнд баримтжуулна.

7.1.7. ажил, үүргээ гүйцэтгэх үед байгаль, цаг уур, гал, усны гэнэтийн аюул, цацраг идэвхит болон химийн бодисын нөлөөлөл, биологийн гаралтай гоц халдварт өвчин үүсгэгч, хөнөөх хэрэгсэл, сүйрэл, дэлбэрэлт зэрэг гамшгийн үед;

Тайлбар: Онцгой байдлын газар, Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Цаг уур, орчны шинжилгээний газрын мэдээлэлд үндэслэнэ.

7.2. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улмаас ажилтны эрүүл мэндэд хүнд гэмтэл, бэртэл учирсан, нас барсны улмаас мэргэжлийн байгууллагын шинжилгээ, магадлагаа шаардлагатай бол 30 хоногийн дотор судлан бүртгэнэ.

7.3. Дүрмийн 1 дүгээр хавсралтаар баталсан “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэсэн акт”-ыг бөглөхдөө үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэхэд шаардлагатай мэдээлэл, баримт бичгүүдийг үндэслэн, үл буруутгах зарчимд тулгуурлан, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын шалтгаан, хүчин зүйлийг тогтоон, дүгнэлт хийж, шийдвэрийг гаргана.

7.4. Бүлэг үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан тохиолдолд осолдогч тус бүрээр холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн, актыг үйлдэнэ.

7.5. Хөдөлмөр эрхлэгч иргэн ажил үүргээ гүйцэтгэхдээ хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны горимыг санаатай зөрчсөн, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн, гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйг үйлдсэний улмаас өөрийн биед гэмтэл, хохирол учруулсан нь энэхүү дүрмийн 6.1-д хамаарах баримт бичиг, мэдээлэл тайлбар, ослын нөхцөл байдлын фото зураг, бичлэг, холбогдох мэргэжлийн байгууллагууд /шүүх шинжилгээний болон цагдаагийн/-ын үзлэг шинжилгээний дүгнэлтээр нотлогдсон тохиолдолд комиссын хурлын протоколд тусгайлан тэмдэглэж, акт тогтоохгүйгээр шийдвэрлэнэ. Холбогдох баримтуудыг болон шийдвэрийг осолдогчид /нас барсан тохиолдолд гэр бүлд/ танилцуулна.

Тайлбар: Тухайн ажил үүргийг гүйцэтгэх хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны горим /тогтсон дэглэм, эмх журам/ -той өмнө нь ажилтан танилцсан, энэ талаар хэвшсэн ойлголттой болсон, тухайн горимтой холбоотой сургалтад хамрагдсан, шалгалт өгч тэнцсэн, заавар зааварчилгаа авсан талаарх материалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны горимыг санаатай зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг тогтооно.

7.6. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг тогтоосон акт болон холбогдох бусад баримт бичгийг тус бүр 4 хувь үйлдэж, актад комиссын дарга, гишүүд гарын үсэг зурж, байгууллагын тамга, тэмдэг дарна.

7.7. Комисс нь судлан бүртгэсэн үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын мэдээллийг үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын цахим бүртгэлийн <http://om.inspection.gov.mn> системд оруулна.

7.8. Актыг үйлдсэнээс хойш ажлын 3 өдөрт багтаан, холбогдох бичиг баримтын хамт харьяа аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчид хүргүүлнэ.

Найм. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын актыг хянан баталгаажуулах

8.1. Үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэсэн актыг хөдөлмөрийн хяналтын, хурц хордлогыг судлан бүртгэсэн актыг хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч ажлын 5 хоногт багтаан тус тус хянан баталгаажуулна.

8.2. Хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын /ахлах/ байцаагч нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын актыг хянахдаа дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

8.2.1. Комисс нь энэхүү осол, хурц хордлогын талаарх мэдээллийг дүрмийн дагуу мэдээлсэн эсэх;

8.2.2. Комисс нь шаардлагатай холбогдох бичиг баримтуудыг бүрдүүлсэн эсэх /Удирдлагын тогтоцооны, техник технологийн, ажлын байр орчны, хүний/;

8.2.3. Комисс нь үл буруутгах зарчмыг баримтлан осол, хурц хордлогын шалтгаан, хүчин зүйлийг бичиг баримтуудыг үндэслэн оновчтой, зөв тогтоосон эсэх;

8.2.4. Мэргэжлийн байгууллагуудын үзлэг шинжилгээний дүгнэлт материалыг хавсаргасан эсэх;

8.2.5. Комисс нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын актын дүгнэлтийг эрх зүйн үндэслэлтэй тогтоосон, шийдвэрийг оновчтой гаргасан эсэх;

8.3. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын акт, холбогдох бичиг баримтын бүрдүүлэлтийг хянасан улсын байцаагч дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

8.3.1. Актын дүгнэлт, шийдвэрийг зөвшөөрч баталгаажуулах;

8.3.2. Актын дүгнэлт, шийдвэрийг зөвшөөрөөгүй бол дүгнэлт гаргах;

8.4. Хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч нь актын дүгнэлт, шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд дүгнэлтээ тусад нь гаргаж, дүгнэлтийг комисс болон осолдогч /нас барсан тохиолдолд гэр бүлд/-д тус тус хүргүүлнэ. Энэ тохиолдолд комиссоос гаргасан актын баталгаажуулах хэсэгт “хүлээн зөвшөөрөөгүй” гэсэн тэмдэглэгээ хийж, ургийн овог, эцэг (эх)-ийн болон өөрийн нэрээ бичиж, гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарна.

8.5. Актын дүгнэлт, шийдвэрийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд хянан баталгаажуулсан акт, холбогдох бичиг баримтуудыг комисст хүлээлгэж өгнө.

8.6. Комисс болон улсын байцаагчийн харьяалах хөдөлмөрийн асуудал эрхэлсэн байгууллага нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын акт, холбогдох бичиг баримтуудын хувийг архивын нэгж болгон хадгална.

Ес. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын мэдээллийн сан

9.1. Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын цахим бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан (цаашид "мэдээллийн нэгдсэн сан" гэх)-тай байна.

9.2. Мэдээллийн нэгдсэн сан нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг мэдээлэх, судлан бүртгэх, тайлагнах үйл ажиллагааг цахимаар зохион байгуулах, үйл ажиллагаанд хяналт тавих, үйл ажиллагааг ил тод болгох, судалгаа, шинжилгээ, үнэлгээ хийх, тайлан, мэдээ гаргах, төрийн байгууллага хооронд мэдээлэл харилцан солилцох, бусад цахим үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

9.3. Мэдээллийн нэгдсэн санд бүх үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын мэдээлэл, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын комиссын судлан бүртгэсэн үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын акт болон гаргасан шийдвэрийг бүртгэж хөтөлнө.

9.4. Мэдээллийн нэгдсэн сан нь Үндэсний статистикийн хорооны даргын тушаалаар зөвшөөрснөөр Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн сайдын тушаалаар батлагдсан бүртгэлийн /ҮОХХ-1/, захиргааны /ҮОХХ-2, ҮОХХ-3, ҮОХХ-4, ҮОХХ-5, ҮОХХ-6/, албан ёсны /ҮОХХ-7, ҮОХХ-8/ маягтуудаар мэдээлэл бэлтгэнэ.

9.5. Мэдээллийн нэгдсэн санд нэвтрэх, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын талаарх мэдээлэл оруулах, бүртгэл үүсэхэд дор дурдсан мэдээллийг тусгасан байна. Үүнд:

- ажил олгогчийн мэдээлэл /байгууллагын нэр, байгууллагын регистрийн дугаар, нийт ажилтны тоо (эрэгтэй, эмэгтэй), байгууллагын хаяг, хариуцлагын хэлбэр, үйл ажиллагааны чиглэл, хэрэв бүлэг осол, хурц хордлого гарсан өртсөн хүний тоо/,

- осолдогчийн тухай мэдээлэл /осолдогчийн овог нэр, хүйс, төрсөн огноо, иргэний харьяалал, хөдөлмөр эрхлэлтийн статус, осол, хурц хордлого гарах үед эрхэлж байсан ажил мэргэжил, ажилласан хугацаа, хамрагдсан сургалт/,

- гэмтлийн тухай мэдээлэл /гэмтлийн төрөл, биеийн аль хэсэгт гэмтсэн/,

- үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тухай мэдээлэл /үйлдвэрлэлийн осол, хурц хордлого аль нь болох, осол, хурц хордлого гарсан орчин, осол, хурц хордлогын хэлбэр, шалтгаан, хүчин зүйл, осол, хурц хордлого гарсан огноо, хугацаа/,

9.6. Мэдээллийн нэгдсэн санд нэвтрэн үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын талаарх мэдээлэл оруулах, бүртгэл үүсгэх эрх нь ажил олгогч, орон тооны бус байнгын комисс, бусад мэргэжлийн байгууллагуудад байна.

9.7. Мэдээллийн сан нь Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас гаргасан аргачлалын дагуу ослын хувь хэмжээний тооцооллыг хийх боломжтой байна.

9.8. Бүртгэлийн маягтыг хэрхэн нөхөх заавруудыг болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэхтэй холбоотой хууль тогтоомжууд, хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчдын бүртгэлийг тухай бүрд шинэчлэл хийн, цахим системд байршуулсан байна.

9.9. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын комиссын нарийн бичиг дарга тухайн комиссын шийдвэрийг цаг тухайд нь мэдээллийн нэгдсэн санд оруулж, үнэн зөв байдлыг нь хариуцна.

9.10. Мэдээллийн системд бүртгэгдсэн үйлдвэрлэлийг осол, хурц хордлогын актыг хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч хянаж баталгаажуулах, буруу бүртгэлийг дахин засуулах эрхтэй байна.

9.11. Энэ дүрмийн 9.5-т заасан мэдээллийн нууцлалыг хангах, хамгаалах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллана.

Арав. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан тухай тайлан гаргах

10.1. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын цахим бүртгэлийн мэдээллийн сан <http://om.inspection.gov.mn> систем нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тайлан мэдээллийн үндсэн эх сурвалж байна.

10.2. Тухайн тайлант хугацаанд аймаг, нийслэлд болон эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудад бүртгэгдсэн үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын мэдээлэл, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улмаас үүссэн гэмтлийн мэдээлэл, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан байгууллагын бүртгэл, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн осолдогчийн бүртгэл нь захиргааны мэдээлэл байна. Дүрмийн 9.5-д тусгагдсан мэдээллүүдээс захиргааны мэдээллийг батлагдсан маягтын дагуу боловсруулна.

10.3. Дүрмийн 9.5-д тусгагдсан мэдээллүүдээс улирал тус бүрд тогтоосон маягтын дагуу бүс, аймаг, нийслэлээр болон эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ангилан боловсруулсан мэдээлэл нь албан ёсны мэдээлэл байна. Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Салбарын хяналтын газар нь албан ёсны мэдээллийг 1, 4, 7, 10 сарын 6-ны дотор Үндэсний статистикийн хороонд маягт болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

Арван нэг. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлоготой холбогдсон маргааныг шийдвэрлэх

11.1. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын талаарх акт, дүгнэлтийг ажил олгогч болон осолдогч (осолдогч нас барсан тохиолдолд түүний гэр бүл) зөвшөөрөхгүй тохиолдолд гомдлоо Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Салбарын хяналтын газар болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын салбарын хяналтын улсын ахлах байцаагчид, эсхүл шүүхэд хандан гаргаж, холбогдох хуулийн дагуу шийдвэрлүүлнэ.

11.2. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарснаас хойш 6 сарын хугацаа өнгөрсөн тохиолдолд акт, дүгнэлт нөхөн гаргахгүй.

TƏCƏL